

## КОМПАНИЙН 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### 1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Хөнгөн бетон ХК нь гол түүхий эд нийлүүлэгч компанид олон жилийн өглөгийг хөрөнгө шилжүүлэхээр шүүхийн явцад эвлэрсэн. Одоогоор шилжүүлж чадаагүй байгаа бөгөөд газар нь банкны барьцаанд байгаа юм. Түрээсийн гэрээ нь их хэмжээний хэлцэлд тооцогдох ба жил бүр гэрээг дүгнэн явж байна. 2019 оноос компани бүхэлдээ зогсож зөвхөн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байна. Компанийн орлого нэмэгдүүлэх зорилгоор компанийн үл хөдлөх хөрөнгийг бүхэлд нь “Бэст терминал” ХХК-д түрээсэлсэн. Түрээсийн орлогоос компанийн ашиглалтын зардал болон зээлийн хүүгээ төлж байна.

### 2. Удирдлагын талаарх мэдээлэл

Компанийн шинэ удирдлага нь дээрх хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас компанийг хэвийн авч явахад хүндрэлтэй байсан ба санхүүгийн тайлан балансыг гадны байгууллагаар хийлгэж ирсэн. Ажиллах хүч, хүний нөөцийг түрээслэгч компани болон Бэст Терминал ХХК-д шилжүүлсэн.

### 3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл

Компани түрээсийн орлогоор өр төлбөрийг төлж байгаа хэдий ч дансны өглөг 2,188,785.1₮, цалингийн өглөг 276,112.8₮, Тавтарын өр 561,648.8₮, урт хугацаат зээл 3,352,283.9₮ байна. 2019 оны 4 сараас эхлэн Хас банкны зээлийн үндсэн зээлийн төлөлт сар бүр төлөгдөж байна. Өмнөх 197,682.4₮-ийн дансны авлагатай байсныг барагдуулж дууссан.

### Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

“Хөнгөн бетон” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 179,373 ширхэг. 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн 5 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн судалгаагаар дараах байдлаар хувьцаа эзэмшиж байна.

Д/д	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Тоо ширхэг	Хувь
1	Б.Наранзул	57,399	32,0%
2	Н.Эрдэмбилэг	53,842	30,0%
3	Б.Наранцацралт	26,655	15,0%
4	Н.Эрдэмбаяр	23,306	13,0%
5	“Минжит булган гол” ХХК	14,918	8,3%
6	Т.Баярхүү	1,034	0,6
		<b>177,154</b>	<b>98,9%</b>

ТУЗ-ИЙН ДАРГА  Б.НАРАНЗУЛ

